

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД БОЛОН ШАДАР САЙДААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН  
БАТЛАМЖИЙН БИЕЛЭЛТ

2009.12.25

Булган аймаг.

№	Биелэлт тооцох заалт	Биелэлт	Хувь
1.	Аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхолыг илэрхийлж Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 2008-2012 оны мөрийн хөтөлбөрийн 4 бүлгийн 93 зорилтын 172 арга хэмжээний хэрэгжилтийг сум, агентлаг байгууллагуудаар гаргуулж авч нэгтгэн хагас бүтэн жилээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт мэдээл байгаа бөгөөд 2009 оны жилийн эцсийн байдлаар тухайн жилийн хэрэгжилт 91,0 хувийн биелэлттэй байна.	90
2.	Төр засгийн төлөөлөгчийн хувьд төрийн хууль ёсыг чандлан сахиж Монгол Улсын үндсэн хууль бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана	Төрийн хууль тогтоомжийн чандлан сахиж байгаа байдал нь бүх шатны Засаг дарга нарын шийдвэрийн хууль зүйн үндэслэл хангагдсан байдлаар илрэнэ. Аймгийн Засаг даргын захирамжийн төслийг хууль зүйн ямарваа нэгэн зөрчил алдаа гаргахгүй байх талаас нь хянаж санал дүгнэлт өгч, сумын Засаг даргын захирамжийг улирал бүр татан авч хянаж, зөвлөгөө өгч байна. Энэ онд аймгийн Засаг даргын 405 захирамж батлагдаж, хэм хэмжээ тогтоосон нэг шийдвэрийг улсын бүртгэлд бүртгүүлээ. Аймгийн Засаг даргын 244 дүгээр захирамжаар батлагдсан журмын дагуу сумдаас хуулийн биелэлтийг тооцож ирүүлсэн мэдээг нэгтгэн ажиллаж дээд газарт уламжлаад байна. Аймгийн Засаг даргын хувьд хуулийн биелэлт тооцох ажилд агентлагуудыг татан оролцуулах, захиргааны хариуцлагын тухай хуулиар захиргааны шийтгэл оногдуулах эрх олгогдсон сум, багийн Засаг дарга нар, Олон нийтийн байцаагч нарыг торгууль, шийтгэвэрийн хуудсаар хангаж, хуулиар олгогдсон бүрэн эрхийг нэгмөр хэрэгжүүлэх чиглэлээр судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авах чиглэл гарлаа. Цаашид хуулийн биелэлтэнд тавих дотоодын хяналтыг сайжруулж, биелэлт тооцож дүгнэх аргачилалд зарим өөрчлөлтийг хийж ажиллаа.	100
3.	Төрийн үйлчилгээг хүнд суртал чирэгдлээс ангид байлган, иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар шуурхай үйлчилнэ	Төрийн үйлчилгээг нээлттэй ил тод байдлаар иргэдэд хүргэх үүднээс Засгийн газраас баталсан 143-р тогтоолын дагуу шалгуур үзүүлэлт тогтоон ажиллаж байгаа бөгөөд төр төсвийн бүх байгууллагууд ил тод байдлыг хангасан иргэдэд нээлттэйгээр ажиллах чиглэлээр самбар гаргаж шударгаар үйлчилэж байгууллагын соёлоо тодорхойлж ажиллаа.	100

4.	Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авилгал, хээл хахуулийг цээрлэн ажиллана.	Тус аймаг санхүүгийн хувьд бие дааж орлогоороо зарлагаа нөхөж улсын төсөвт 2009 онд 600,0 сая төгрөг төвлөрүүлж ажиллаа. Санхүү эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор УИХ 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж бараа үйлчилгээний бусад зардлыг 30 хүртэл хувиар бууруулж баталсан. Иймд батлагдсан төсөвтөө багтааж зардлын зүйл хооронд гүйлгэн шилжүүлэх замаар төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласнаар орон нутгийн төсвийн байгууллагууд өргүй гарлаа.	100
5.	Аймгийн эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ, соёл, боловсрол, эрүүл мэндийн зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулж ажиллана.	<p>аймгийн боловсрол соёлын салбарын үйл ажиллагааны орчин бүрдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн ажиллалаа. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж төв, суурин газрын хүүхдийн 80-аас доошгүй хувь нь цэцэрлэгт хамрагдсанаас гадна нийт 1420 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол олгох хувилбарт сургалтад хамрагдсанаас зуны цэцэрлэгт 895, ээлжийн бүлгээр 302, явуулын багш 283 хүүхдийг сургалтанд хамруулсан байна. Үүнээс “Чех Каритас” төслийн явуулын сургалт 5 сумын 13 багийн 189 хүүхдийг хамруулан сургажээ.</p> <p>Сургуульд орж байгаа хүүхдийн 90-ээс доошгүй хувийг сургуульд бэлтгэх зорилт тавьж, сургуульд орох хүүхдийн судалгааг гарган 708 хүүхдийг цэцэрлэгээр, хувилбарт сургалтаар 213 хүүхэд бэлтгэснээр 1-р ангид орох хүүхдийн 93.5 хувь нь сургуульд бэлтгэх сургалтад хамрагдсан байна.</p> <p>2009 онд 1400 багш мэдлэг боловсролоо дээшлүүлсний 854 нь орон нутагт, 265 нь бүсийн, 122 багш төвлөрсөн, 160 гаруй багш ажлын байранд тус тус мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагджээ. Мөн Малайз, Сингапур, БНСУ-д БСГ-ын мэргэжилтэн, мэдээлэл зүйн багш тус бүр 1 хүний мэргэшлийг дээшлүүлсэн байна. Хутаг-өндөр суманд соёлын төвийн эрхлэгч нарын сургалт семинарыг хийж, 17 хүнийг хамруулан туршлага солилцсон нь үр дүнтэй ажил боллоо.</p> <p>Сумдын соёлын төвүүдийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, “Соёлын төв чанартай үйлчилгээ-2” болзолт уралдааныг дүгнэн сумдын соёлын төвүүдийг мөнгөн шагналаар урамшууллаа. Аймгийн Төв номын сан интернэтэд холбогдон, электрон номын сантай болж, номын фондод байгаа номыг бүртгэлд оруулж байна.</p> <p>Барилгын засварын ажлын хөрөнгийн эх үүсвэрийг улсын төвлөрсөн төсөв болон төсөл хөтөлбөрийн газруудад хандан ээлж дараатайгаар шийдвэрлэж ирснээр боловсрол соёлын салбарт 1.8 тэрбум гаруй төгрөгийн</p>	100

хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр бий болгох зорилгоор 2009 онд байнгын 770, улирлын 328, нийт 1098 ажлын байр бий болголоо.

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Хутаг-Өндөр, Гурванбулаг, Могод, Сэлэнгэ сумдын 30 малчин өрх хамрагдаж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжиж 70.0 шахам сая төгрөгийн санхүүжилт хийгдлээ.

2009 оны 1.2 дугаар сард аймгийн хэмжээнд “Оролцооны аргаар өрх, хүн амын амьжиргааны түвшин тогтоох үзлэг”-ийг зохион байгуулж “Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан ИТХ-ын хуралдаанаар батлуулан хэрэгжүүлж байна.

Өрхийн амьжиргааны түвшинг тогтоосон үзлэгийн дүнг үндэслэн аймгийн хэмжээнд нийт 400 өрхийг сонгон өрх бүр дээр “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулж, амьжиргааг нь дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллалаа.

Эрүүл мэндийн салбарт өнгөрсөн онд “Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, эрүүл мэндийн салбарын удирдах ажилтаны зөвөлгөөнийг байгуулан, зөвөлгөөнөөс эрүүл мэндийн системийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллалаа.

Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа мэргэжилтэнүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөр”, “ Эрүүл мэндийн салбарт ажиллагсадын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж, орон нутагт 15 удаагийн сургалтанд 300 гаруй эмнэлгийн мэргэжилтэнийг, Улаанбаатар хотод 55 эмнэлгийн мэргэжилтэнг богино хугацааны сургалтанд хамруулсан.

Аймгийн хэмжээнд 189940 хүнд амбулаторийн үзлэг хийж, нийт үзлэгийн 37 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзлэж байна. Нийт халдварт өвчин 991 тохиолдол гарсан нь өнгөрсөн оныхоос 82 тохиолдлоор буурсан байна.

Спортын салбарт нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж, аймгийн хэмжээнд 2009-2012 онд биеийн тамир спортын талаар баримтлан ажиллах бодлогыг боловруулан гаргалаа.

Цанын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг Бугат суманд

		<p>зохион байгуулан 10 байгууллагын 13 баг тамирчид оролцон Булган аймгийн тамирчид эхний байранд шалгарч алтан медалийн эзэд болсон.</p> <p>Аймгийн аварга шалгаруулах тэмүүэнийг 13 төрлөөр зохион байгуулан явуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах ажлыг зохион байгуулан явуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд нийтийн биеийн тамирын 50гаруй уралдаан тэмцээнийг зохион байгуулан давхардсан тоогоор 5000 гаруй хүн хамрагдаж, 7350 хүн бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох үзлэгт хамрууллаа.</p> <p>Биеийн тамир , спортын арга хэмжээг өргөнөөр сурталчлах зорилгоор “ Спортын мэдээ” сонинг улиралд тутам гарган ажиллаж байна.</p>	
6.	<p>Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, архи дан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга, хариуцлагыг өндөржүүлж ажиллана.</p>	<p>Аймгийн хэмжээнд “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын жил” болгон зарлаж, жилийн ажлын удирдамж төлөвлөгөө гарган, явцын байдалд 2 удаа хяналт үнэлгээ хийж ажиллаа. Жилийн ажлын үр дүнд албан хаагч бүр эрхэлсэн ажилдаа хариуцлагатай ханддаг, бүх шатны ажлын хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой ахиц гарлаа.</p> <p>Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журам хангах ажлыг бодлого зохицуулалтаар хангаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран сумын эрүү хэв журмын нөхцөл байдалтай уялдсан урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж энэ онд Хишиг-Өндөр, Орхон, Могод, Сайхан сумдад ажиллаа. Урьдчилан сэргийлэх сурталчилгааны материалын эх бэлтгэх уралдааныг 2 удаа зарлан дүгнэж нийт 30 төрлийн 2000 гаруй сурталчилгааны материал хэвлүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх соен гэгээрүүлэх сарын аян зарлаж, Хүний эрхийн өдрийг тохиолдуулан “Хүний эрх” мэдээлэл сурталчилгааны өдөрлөгийг шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Архидан согтуурахтэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр архи согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгүүдэд аттестатчилал явуулж, тусгай зөвшөөрөлтэй цэгүүдийн хандиваар Архидан согтуурахтэй тэмцэх сан бүрдүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн оролцоотой зохион байгуулах ажил амжилттай эхлэлээ тавилаа. Архидан согтуурахтай тэмцэх хяналт тавих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийх ажлыг эхэлж, аймгийн хэмжээнд байгаа архи хэтрүүлэн хэрэглэгч архинд донтох өвчтэй иргэдийн</p>	90

		судалгааг гаргалаа. Цаашид эдгээр хүмүүст албадан болон сэтгэл заслын эмчилгээнд хамруулахаар ажиллаж байна. Өнгөрсөн онуудад малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр идэвхитэй ажил зохион байгуулсны дүнд энэ онд малын хулгайн гэмт хэрэг өмнөх оноос 10 буюу 20 хувиар буурч, ашиглал, албан тушаалын гэмт хэрэг, байгаль орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргүүд өмнөх оноос өссөн байна. Энэ онд аймгийн хэмжээнд нийт 240 гэмт хэрэг гарсан нь өмнөх оноос 17 хэргээр буюу 7,6 хувиар, гэмт хэргийн илрүүлэлт 68,8 хувьд хүрч өмнөх оноос 35,6 хувиар өссөн байна.	
7.	Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, удирдах бусад албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг туслалцааг авч ажиллана.	Монгол улсын Засгийн газар, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, бусад албан тушаалтнуудаас өгсөн үүрэг даалгаварыг шуурхай хэрэгжүүлж үр дүнг тухай бүр тогтмол тайлагнаж цаг үеийн асуудалтай холбоотой аливаа асуудлаар туслалцаа авч ажиллаж ирлээ. Засгийн газрын тогтоол, шийдвэрийн заалтыг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Шийдвэрийн хэрэгжилтийг улирал тутам Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. Засгийн газраас зохион байгуулдаг уулзалтад тогтмол оролцож, зөвлөгөө авч ажиллаж, Яамдтай хамтран ажиллаж байна.	100
8.	Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, авилгал, хээл хахуульд оролцсон, ёс суртахууны доголдол гаргасан, архидан согтуурсан тохиолдолд улстөрийн хариуцлага хүлээнэ. Хариуцлага алдаж албан тушаалаас чөлөөлөгдөх нь	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчиж, ноцтой доголдол гаргаагүй. Төсвийн хөрөнгийг хууль, журмын дагуу зүй зохистой зарцуулж байна. Нутгийн захиргааны байгууллагад төрийн албан хаагчийн ёс зүйн дутагдал илэрсэн тохиолдол бүрт хариуцлага тооцож ажиллах бодлого барьж ажилласны үр дүнд хариуцлага алдаж ажлын байраа орхисон, үүрэг даалгавар биелүүлээгүй албан хаагчидад сахилгын арга хэмжээ аван ажиллалаа. “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын жил”-ийн ажил зарлаж түүнтэй холбогдуулан тайлант онд сахилгын шийтгэл оногдуулсан төрийн албан хаагчийн судалгаа гарган сумдуудаас аван нэгтгэл хийж судалгаатай болох талаар ажиллаж байна.	100

	улс төрийн намын хаацайлалыг эрэлхийлэх шалтгаан болохгүй		
9.	Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг хагас жил тутам Засгийн газарт тайлагнана.	Батламжийн биелэлтийг сум, агентлаг, байгууллагуудаар тооцуулан гаргаж хагас, болон жилийн эцсийн байдлаар дүгнэн Засгийн газарт тайлагнасан бөгөөд Батламжийн биелэлт 2009 оны жилийн эцсийн байдлаар 97,7 хувийн биелэлттэй байна	100

Монгол Улсын Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан батламжийн биелэлт 2009 оны жилийн эцсийн байдлаар 97,7 хувийн биелэлттэй байна.

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР